

БАТЛАВ:

Монголын Таеквондогийн холбооны

Ерөнхийлөгч  Б.Онон



Улаанбаатар хот

2022.03.29

ГҮП ЗЭРЭГ ДЭВШИХ ШАЛГАЛТ АВАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журам нь Дэлхийн Таеквондогийн өнгийн бүс буюу гүп зэрэг ахиулах шалгалтын зохион байгуулалт, үүрэг, хариуцлагатай холбогдох харилцааг зохицуулна.
- 1.2. Журмын биелэлтэд Монголын Таеквондогийн холбоо хяналт тавина.
- 1.3. Үндсэн өнгийн буюу 2, 4, 6, 8-р гүп зэргийн шалгалтыг Монголын Таеквондогийн холбооны салбар клуб, гишүүн байгууллага Монголын Таеквондогийн холбооны хяналт дор зохион байгуулна.
- 1.4. Үндсэн өнгийн бүсэн дээр зэрэг нэмсэн буюу 1, 3, 5, 7, 9-р гүп зэргийг тамирчны ур чадвар ахисан байдал, тэмцээн уралдаанд үзүүлсэн амжилт зэргийг нь харгалзан үзэж салбар клуб, гишүүн байгууллага, түүний дасгалжуулагч багш олгоно.
- 1.5. Шалгалтанд бүртгүүлэгч нь Монголын Таеквондогийн холбооны “Гүп зэргийн сургалтын стандарт”- д тусгагдсан мэдлэг, чадварыг эзэмшсэн байна.

Хоёр. Шалгалтын бүртгэл

- 2.1 Бүртгүүлэгч нь шалгалтанд оролцох хүсэлтээ өөрийн харьяа клуб, спорт хороонд хүсэлтээ илгээнэ.
- 2.2 Бүртгүүлэгч нь дараах материалыг бүрдүүлсэн байна:
 - 2.2.1 Иргэний үнэмлэх буюу түүнтэй адилтгах бичиг баримт;
 - 2.2.2 Цээж зураг /сүүлийн 3 сарын дотор авахуулсан 3x4 см хэмжээтэй/;
 - 2.2.3 Одоо эзэмшиж буй гүп зэргийн батламжны хуулбар;
 - 2.2.4 Улаан бүс буюу 2-р гүп зэрэгт шалгалт өгөгч нь таеквондо пүмсэ төрлийн тэмцээнд оролцсон туршлагатай байх ёстой. Үүнийг нотлох баримтыг хавсаргах. /мандат, өргөмжлөл гэх мэт/
- 2.3 Бүсний шалгалт авах өдрөөс ажлын таваас доошгүй хоногийн өмнө шалгалтад орох тамирчдын нэгдсэн жагсаалт (тус журмын хавсралтад агуулагдах үлгэрчилсэн загвар) болон холбооноос шалгалтын комисс (шүүгч, дасгалжуулагчийн төлөөлөл) илгээх хүсэлтийн хамт Монголын Таеквондогийн холбооны салбар клуб, гишүүн байгууллага Монголын Таеквондогийн холбооны mongoliataekwondo@gmail.com цахим шуудангаар илгээнэ.
- 2.4 Шалгалт явагдаж дууссанаас ажлын 5 хоногийн дотор гүп зэрэг ахисан тамирчны бүсний шинэчлэгдсэн мэдээллийг Монголын Таеквондогийн холбооны албан ёсны бүртгэлийн нэгдсэн систем болох www.mongol-taekwondo.com сайтад оруулж баталгаажуулна. /Тухайн байгууллагын багш, дасгалжуулагч өөрийн админ эрхээр бүртгэлийг шинэчлэх ба шалгалтын комисс шинэчлэлийг шалгаж баталгаажуулна/

Гурав. Шалгалтын хураамж

3.1 Гүп зэргийн ангиллаас хамаарч шалгалтын хураамж харилцан адилгүй байна.

Бүсний зэрэг	Шалгалтын хураамж
Шар бүс /8-р гүп зэрэг/	30.000 төгрөг
Ногоон бүс /6-р гүп зэрэг/	40.000 төгрөг
Цэнхэр бүс /4-р гүп зэрэг/	50.000 төгрөг
Улаан бүс /2-р гүп зэрэг/	60.000 төгрөг

3.2 Монголын таеквондогийн холбооноос томилогдсон шалгалтын комиссын гишүүдийн тухайн өдөр ажилласан цалинг тухайн клуб, байгууллага хариуцах ба дараах шатлалтай байна.

Дасгалжуулагчийн төлөөлөл	Өдрийн цалин
Дасгалжуулагчийн зөвлөлийн гишүүн дасгалжуулагч	100,000 төгрөг
Хар бүс V дангаас дээш дантай дасгалжуулагч	150,000 төгрөг

Шүүгчийн төлөөлөл	Өдрийн цалин
Монгол улсын шүүгч	100,000 төгрөг
Олон улсын шүүгч	150,000 төгрөг

Дөрөв. Шалгалтын дүн

- 4.1 Шалгалтад оролцогч нь гүп зэргийн стандартад заасан шаардлага, түүний гүйцэтгэлд өгсөн шалгалтын комиссын үнэлгээнд үндэслэн шалгалтын дүнг гаргана.
- 4.2 Шалгалтад тэнцээгүй тохиолдолд тухайн байгууллагын дараагийн шалгалт авах хугацаанд шалгалтаа дахин өгнө.
- 4.3 Шалгалтын комисс нь шалгалтад орсон тамирчны шалгалтын үр дүнгийн мэдээллийг тухайн өдөрт нь танилцуулна.

Тав. Гэрчилгээ олгох

- 5.1 Амжилттай шалгуулагчид гүп зэрэг ахисан болохыг батламжилсан батламж болон үнэмлэхийг олгоно.
- 5.2 Гүп зэргийн батламж нь тус гэрээний хавсралт дахь батламжийн стандарт загвар байна.